



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

15160 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Хуульчдын гудамж 13/1  
Утас: 321138, Факс: (976-11) 322936  
E-mail: info@nduz.gov.mn  
http: nduz.gov.mn

2019.03.29 № 36

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


「НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ  
СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА Д.ОЮУНХОРОЛ ТАНАА

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн  
2018 оны үйл ажиллагааны тайланг хүргүүллээ.  
Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 6/ хуудастай.

Хувийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт.

ДАРГА *S. Chinzorig* С.ЧИНЗОРИГ



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**АГУУЛГА**

- 1. Нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын хүрээнд**
  - 1.1. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр**
  - 1.2. Засгийн Газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр**
  - 1.3. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр**
  
- 2. Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл**
  - 2.1. Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсөв**
  - 2.2. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл**
    - 2.2.1. Нийгмийн даатгалын сангийн орлого**
    - 2.2.2. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт**
  - 2.3. Нийгмийн даатгалын хамралт**
  
- 3. Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж болон төлбөр, зардал**
  - 3.1. Тэтгэврийн даатгалын сан**
  - 3.2. Тэтгэмжийн даатгалын сан**
  - 3.3. ҮОМШӨ-ний даатгалын сан**
  - 3.4. Ажилгүйдлийн даатгалын сан**
  - 3.5. Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт**
  
- 4. Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа**
  - 4.1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалт**
  - 4.2. Хүний нөөц**
  - 4.3. Нийгмийн даатгалын үйлчилгээ хөгжүүлэлт**
  - 4.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр**
  - 4.5. Хяналт, шалгалтын үр дүн**
  - 4.6. Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа**
  - 4.7. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах**
  - 4.8. Түншлэл, хамтын ажиллагаа**
  - 4.9. Лавлах үйлчилгээний талаар**
  
- 5. Нийгмийн даатгалын салбарын бодлого, үйл ажиллагааны үр нөлөө**
  
- 6. Цаашид тавих зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ**

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
БХ	Байнгын Хороо
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
ЗГ	Засгийн газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НД	Нийгмийн даатгал
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗ	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ЭМ	Эрүүл мэнд
ХХТАО	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ОХУ	Оросын Холбооны Улс

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны зарцуулсан хөрөнгө болон үйлчлүүлсэн хүний тоо

Хүснэгт 4. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 5. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 6. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 7. НД-ын салбарын ажилтнуудын бүтэц

Хүснэгт 8. Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн байдал

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв

График 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц

График 3. Нийгмийн даатгалын үйлчилгээ авагчдын тоо

График 4. Нийгмийн даатгалын хамралт

График 5. Тэтгэвэр авагчдын бүтэц

График 6. Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ

График 7. Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага

График 8. ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлага

График 9. Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага

График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

График 11. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

График 12. Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц

**ХАВСРАЛТ МАТЕРИАЛ**

- Хавсралт 1. Нийгмийн даатгалын салбарт холбогдох эрх зүйн актын 2018 оны хэрэгжилтийн мэдээ
- Хавсралт 2. Монгол улсын их хурлын нийгмийн бодлого, боловсрол, соёл, Шинжлэх ухааны байнгын хорооноос өгсөн чиглэлийн хэрэгжилт

## 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАЛААРХ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ АЖЛЫН ХҮРЭЭНД

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2018 онд 9 удаа хуралдаж, 31 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 16 тогтоол шийдвэрийг баталж гарган, нийгмийн даатгалын салбарыг нэгдсэн удирдлагаар ханган ажиллалаа.

### 1.1. Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр.

*Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалыг батлуулсан.*

➤ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн болон олон нийтийн байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан байгуулж, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын төслийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулсан.

*Тэтгэврийн параметрийг өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулав.*

➤ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэврийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн, 20 жил 3 сараас дээш хугацаанд шимтгэл төлсөн бол 60/55 насандаа тэтгэвэр тогтоолгох зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулав.

➤ Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар ажил олгогчийн болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тус тус 1.0 пунктээр нэмэгдүүлэн 8.0 хувь болгон өөрчилсөн. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд энэ хуулийг хэрэгжүүлж ажилласнаар 2018 оны байдлаар тэтгэврийн даатгалын санд 1,139.2 тэрбум төгрөг хуримтлуулсан бөгөөд энэ нь 2017 онтой харьцуулахад 258.9 тэрбум төгрөгөөр өссөн.

*Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн.*

➤ УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 10 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгээс нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа, нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг шалгаад тодорхой чиглэл өгсөн. ХНХЯ, НДҮЗ, НДЕГ нь энэхүү чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор зүйл, заалт бүрээр нь хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, НДҮЗ-ийн дүрэмд өөрчлөлт оруулан, нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдах, хүүгийн орлогыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулан хийж, мэдээллийг улирал бүр гарган НББСШУБХ-нд хүргүүлж байна.

*НББСШУБХ-оос өгсөн чиглэлийг хэрэгжүүлж байна.*

*Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлуулав.*

➤ Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасны дагуу Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийг УИХ-ын НББСШУБХ-ны 2018 оны 07 дугаар сарын 30-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан. Уг дүрэмд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зарчим, Зөвлөлийн хуралдаан, дарга, гишүүний бүрэн эрх, Ажлын албаны үйл ажиллагааг тодорхой болгох талаар нэмэлт өөрчлөлтүүд орсон.

## 1.2 Засгийн Газраас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр.

➤ Засгийн Газрын 2018 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 16 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 27.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 280.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 243.0 мянган төгрөг болов.

*Тэтгэврийн хэмжээг 9 орчим хувиар нэмэгдүүлсэн.*

*Тэтгэврийн зээлийн хүүг дахин бууруулав.*

➤ Тэтгэвэр олгодог арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2018 онд 12 сар хүртэлх тэтгэврийн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 3-6 пунктээр бууруулан, сарын 1 хувь, жилийн 12 хувь болгосноор нийт 43290 тэтгэвэр авагч 42.1 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авч, тэтгэвэр авагчид 1.6 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна.

➤ Малчдын өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулснаар 6.8 мянган малчинд тэтгэвэр тогтоож, тэтгэвэрт 12.1 тэрбум төгрөг зарцуулав. Түүнчлэн Засгийн Газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан

*Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан шийдвэрийг хэрэгжүүлж байна.*



“Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”, “Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам”-ын дагуу 2018 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 337 сум, 3 дүүрэгт зөвлөл байгуулагдан ажиллаж, 1693 малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 1442 малчны өндөр насны тэтгэвэрт гарах хугацааг тогтоов.

**1.3. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр.**

➤ Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр тогтоолоор “Агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт чиг үүрэг нь шилжиж байгаа албан хаагчдыг шилжүүлж, 1.9 тэрбум төгрөгийн өртөгтэй конторын барилга, 650.7 сая төгрөгийн өртөг бүхий 966 ширхэг эд хөрөнгийг шилжүүлэв.

*Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт холбогдох эд хөрөнгийг шилжүүлэв.*

*Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтцийг батлав.*

➤ Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор “Агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын чиг, үүрэгт өөрчлөлт орж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болж өөрчлөн зохион байгуулагдахаар шийдвэрлэсэн тул Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6-д “Нийгмийн даатгалын даатгалын Үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах ... эрхтэй” гэж заасныг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталж, мөрдүүлсэн.

➤ Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д “Хуримтлалын сангаас арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл хамтран тогтооно” гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 600.0 тэрбум төгрөгөөр тогтоосон.

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад байршуулах дээд хэмжээг 600.0 тэрбум төгрөгөөр тогтоосон.*

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд байршуулах журам, Мөнгөн хадгаламжийн гэрээний загварыг шинэчлэн баталсан.*

➤ Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дэх заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж

хэлбэрээр байршуулах журам, Мөнгөн хадгаламжийн гэрээний загварыг тус тус шинэчлэн баталсан.

➤ Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 09, 13 дугаар тогтоолуудаар Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.6 дахь заалт, “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ын 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн 1 жилийн хүүгийн хэмжээг Монголбанкны бодлогын хүү болон эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 13.0-14.0 хувиас багагүй байхаар тогтоосон.

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн жилийн хүүг тогтоосон.*


## 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсөв

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогын хэмжээг 1,911.2 тэрбум төгрөг, үүнээс: нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1,301.4 тэрбум, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 609.8 тэрбум төгрөгөөр баталсан. Мөн хуулиар төсвийн нийт зарлага 1,808.3 тэрбум төгрөг, үүнээс: тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээний зардалд 1,789.3 тэрбум, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 19.0 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан.

Нийгмийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/

График 1.




2.2. Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл

2.2.1. Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,301.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,480.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 113.7 хувиар биелүүлсэн. /дүнд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 609.8 тэрбум төгрөг ороогүй/

Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц /хувиар/

График 2.



Нийгмийн даатгалын сангийн нийт орлогын 30.6 хувь буюу 639.5 тэрбум төгрөгийг ажил олгогч, 25.9 хувь буюу 541.4 тэрбум төгрөгийг даатгуулагчийн шимтгэл, 3.7 хувь буюу 76.4 тэрбум төгрөгийг сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулсан мөнгөн хадгаламжийн болон Засгийн Газрын бондын хүүгийн орлого, бусад орлогоор тус тус бүрдүүлсэн.

Мөн орлогын 29.2 хувь буюу 609.8 тэрбум төгрөг нь тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс авсан дэмжлэг эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт /тэрбум төгрөг/

Хүснэгт 1.

№	Орлогын төрөл	2017	2018	Өөрчлөлт	Өсөлтийн хувь
1	Улсын төсвөөс олгох дэмжлэг	570.2	609.8	39.6	6.5
2	Ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагаас	578.0	639.5	61.5	9.6
3	Төсөвт газраас	175.2	149.7	-25.5	-17.0
4	Даатгуулагчаас	534.8	541.4	6.6	1.2
5	Сайн дурын даатгуулагчаас	62.4	69.2	6.8	9.8
6	Гадаадад ажиллаж буй иргэдийн	2.7	3.0	0.3	10.0
7	ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	0.8	0.8	-	-
8	Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58.6	0	-	-
9	ЭМД-ын бусад даатгуулагчийн шимтгэл	19.9	0	-	-
10	Бусад орлого	113.7	76.4	-37.3	-48.8
<b>Нийт</b>		<b>2116.2</b>	<b>2089.8</b>	<b>-26.5</b>	<b>-1.3</b>

Орлогын бүтцээс харахад бусад орлого 76.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оноос 37.3 тэрбум төгрөгөөр буюу 48.8 хувиар буурсан бөгөөд энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн хадгаламжийг ЭМДЕГ-т шилжүүлсэнтэй холбоотойгоор хүүгийн орлогын хэмжээ буурсан байна.

2018 онд арилжааны 10 банкинд 9-15 хувийн хүүтэй мөнгөн хадгаламж байршуулж 56.6 тэрбум, ЗГ-ын бонд эзэмшиж 2.3 тэрбум төгрөгийн хүүгийн орлого тус тус НД-ын санд төвлөрүүлсэн. Жилийн эцсийн байдлаар нийт 439.3 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж арилжааны банкуудад байршиж байна.

### 2.2.2. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

Нийгмийн даатгалын сангийн зардлыг 1,808.3 тэрбум төгрөг төлөвлөснөөс 1,814.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр авагч, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйл ажиллагааны зардалд олгосон.

#### Нийгмийн даатгалын сангийн 2018 оны зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 2.

№	Зардал	Мөнгөн дүн /тэрбум.төгрөг/	Нийт зардалд эзлэх хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	1,619.3	89.2
2	Тэтгэмжийн даатгалын сан	112.1	6.2
3	ҮОМШӨ-ний даатгалын сан	29.9	1.7
4	Ажилгүйдлийн даатгалын сан	34.3	1.9
5	Үйл ажиллагааны зардал	18.9	1.0
	<b>Нийт</b>	<b>1,814.5</b>	<b>100.0</b>

Нийт зардлын 89.2 хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байгаа бол ҮОМШӨ-ний даатгалын сан 1.7 хувийг эзэлж байна.

#### Нийгмийн даатгалын сангийн 2018 оны зарцуулсан хөрөнгө болон үйлчлүүлсэн хүний тоо


Хүснэгт 3.

№	Нийгмийн даатгалын сан	2017 он		2018 он		өсөлт, бууралт	
		Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Хөрөнгө /тэрбум.төг/
1	Тэтгэврийн	388.6	1417.4	398.1	1619.3	9.5	202.0
2	Тэтгэмжийн	194.4	100.2	209.6	112.1	15.2	11.9
3	ҮОМШӨ-ний	9.6	29.3	9.4	29.9	-0.2	0.6
4	Ажилгүйдлийн	21.2	34.6	21.4	34.3	0.2	-0.2
5	Эрүүл мэндийн	1580.3	288.1	-	-	-	-
6	Үйл ажиллагааны зардал	-	21.2	-	18.9	-	-2.5
	<b>Нийт</b>	<b>2 194.1</b>	<b>1 890.8</b>	<b>638.5</b>	<b>1 814.5</b>	<b>24.7</b>	<b>211.8</b>

2018 онд 638.5 мянган тэтгэвэр авагч, даатгуулагчид 1,795.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ. Нийгмийн даатгалын сангаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 24.7 мянгаар, буюу 3.8 хувиар, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 211.8 тэрбум төгрөгөөр буюу 11.7 хувиар тус тус өссөн бөгөөд Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 18.9 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 10.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ авагчдын тоо /мян.хүн/

График 3.



### 2.3. Нийгмийн даатгалын хамралт

Нийгмийн даатгалын хамралт /мян.хүн/

График 4.



Нийгмийн даатгалын мэдээллийн санд 2018 оны жилийн эцсийн байдлаар 45.8 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь 2017 онтой харьцуулахад 2.3 мянган ажил олгогч буюу 5.3 хувиар нэмэгдсэн.

Мөн албан журмын болон сайн дурын даатгалд 1,104.6 мянган даатгуулагч хамрагдсан нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 81.3 хувийг эзэлж байна.

### 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ҮЗҮҮЛЖ БУЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ БОЛОН ТӨЛБӨР, ЗАРДАЛ

#### 3.1. Тэтгэврийн даатгалын сан

Тайлант жилд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, цэргийн албан хаагчийн тэтгэвэр авч байгаа 398.1 мянган тэтгэвэр авагчид 1.6 их наяд төгрөг зарцуулсан.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 58.2 мянган тэтгэвэр авагч, 17.8 мянган цэргийн албан хаагчдын тэтгэвэрт 335.7 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө


Хүснэгт 4.

№	Тэтгэврийн төрөл	2016 он		2017 он		2018 он	
		Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Тэтгэвэр авагчдын тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/
1	Өндөр насны	268.9	973.7	282.5	1 065.6	293.7	1 222.5
2	Тахир дутуугийн	65.1	174.8	67.8	185.1	66.3	208.2
3	Тэжээгчээ алдсаны	21.0	57.5	20.7	58.8	20.2	64.1
4	Цэргийн	16.7	97.8	17.3	106.3	17.8	122.8
<b>Нийт</b>		<b>371.6</b>	<b>1 302.8</b>	<b>388.5</b>	<b>1 415.8</b>	<b>398.1</b>	<b>1 617.6*</b>

\* Бусад зардал ороогүй болно.

Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/

График 5.




Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 19.5 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 80.5 хувь нь бүрэн тэтгэврийг авч байна.

2018 оны байдлаар нийгмийн даатгалын сангаас олгож буй бүрэн тэтгэврийн доод хэмжээ 280.0 мянган төгрөг буюу амьжиргааны доод түвшингээс 64.9 хувиар илүү байна. Нийгмийн даатгалын сангаас сард 398.1 орчим мянган тэтгэвэр авагчдад 1,617.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

Тэтгэврийн доод болон дундаж хэмжээ /мянган төгрөг/

График 6.



Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 4.8 хувиар өссөн.

3.2. Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас 209.5 мянган даатгуулагчдад 111.9 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгожээ. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.8 тэрбум төгрөгөөр өссөн.

Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө


Хүснэгт 5.

№	Тэтгэмжийн Төрөл	2016 он		2017 он		2018 он	
		Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/
1	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	110.6	12.8	123.4	16.2	133.9	17.9
2	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	58.1	68.4	57.8	70.6	61.5	79.9
3	Оршуулгын тэтгэмж	13.3	11.1	13.2	13.3	14.1	14.1
<b>Нийт</b>		<b>182.0</b>	<b>92.3</b>	<b>194.4</b>	<b>100.1</b>	<b>209.5</b>	<b>111.9*</b>

\* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

График 7




### 3.3. ҮОМШӨ-ний даатгалын сан

ҮОМШӨ-ний даатгалын сан орлогоороо зарлагаа бүрэн нөхдөг бөгөөд 2018 онд тус санд 171.2 тэрбум төгрөгийн орлого хуримтлагдаж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт нийт 46.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

График 8.



2018 оны жилийн эцсийн байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 4.9 мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 26.5 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1.1 мянган иргэний тэтгэмжид 0.7 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд 1.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

ҮОМШӨ-ний даатгалын санд ажил олгогчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээг 0.2 хувиар бууруулсан ч орлогоороо зардлаа бүрэн нөхсөн.



Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 6.

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	2016 он		2017 он		2018 он	
		Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/
1	Тахир дутуугийн тэтгэвэр	4.6	24.1	4.3	23.6	4.3	23.9
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.6	2.5	0.6	2.5	0.6	2.6
3	ХЧТА-ны тэтгэмж	1.0	0.58	1.1	0.6	1.1	0.7
4	Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.022	0.025	0.02	0.02	0.02	0.02
5	Рашаан сувиллын зардал	3.8	1.06	3.6	1.0	3.4	0.9
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	-	0.4	-	0.7	-	0.8
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл	-	0.6	-	0.9	-	0.9
<b>Нийт</b>		<b>10.2</b>	<b>29.7</b>	<b>9.6</b>	<b>29.3</b>	<b>9.4</b>	<b>29.9*</b>


\* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

3.4. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 41.1 тэрбум төгрөг, зарлага 34.7 тэрбум төгрөг болж орлогоороо зарлагаа нөхөж байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

График 9.




2018 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 21.4 мянган даатгуулагч 34.3\* тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж

авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 1.4 хувиар, нийт зарлагын хэмжээ 0.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

\* Үйл ажиллагааны болон бусад зардал ороогүй болно.

Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

График 10.




3.5. Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт

Нийгмийн даатгалын байгууллагын 2018 оны үйл ажиллагааны зардалд 19.02 тэрбум төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 18.9 тэрбум төгрөгийг зарцуулж 0.12 тэрбум төгрөгийг хэмнэсэн. Энэхүү хэмнэлт нь төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, хэмнэлтийн горимоор ажилласантай холбоотой. Нийт урсгал зардлын 70.4 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын салбарын 1.4 мянган ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал /тэрбум төгрөг/

График 11.




4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалт

“Агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрыг Нийгмийн даатгалын ерөнхий газар болгон өөрчилсөнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц шинэчлэгдлээ. НДЕГ нь одоогоор 6 газар, 5 хэлтэс, 1 алба, дэргэдээ 2 төв, 1 төв комисстой ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц

График 12.



#### 4.2 Хүний нөөц

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/25 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/22 дугаар тушаалаар нийгмийн даатгалын салбарын бүтэц орон тоог шинэчлэн тогтоосон бөгөөд одоо салбарын хэмжээнд 1436 ажилтан, албан хаагч ажиллаж байна.

#### НД-ын салбарын ажилтнуудын бүтэц

Хүснэгт 7.

№	Албан тушаалын ангилал	Тоо	Хувь
1	Удирдах албан тушаалтан	41	2.8
2	Гүйцэтгэх албан тушаалтан	1214	84.5
3	Үйлчилгээний	69	4.8
4	Гэрээт ажилтан	112	7.7
Нийт		1436	100

#### 4.3. Нийгмийн даатгалын үйлчилгээ хөгжүүлэлт

*Нийгмийн даатгалын байгууллага цайны цагийн завсарлагагүйгээр иргэдэд үйлчилж эхэллээ.*

➤ 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд тасралтгүй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд үдийн цайны завсарлагагүйгээр үйлчилгээ үзүүлж байна.

➤ Банкны “Qray” үйлчилгээ ашиглан сайн дурын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийг банкинд очилгүйгээр QR код хэрэглэж шилжүүлэх үйлчилгээг 2018 оны 04 дүгээр сараас эхлэн салбарын хэмжээнд нэвтрүүлэв. Одоогоор 645 удаагийн 27,3 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн.

*Банкны “Qray” үйлчилгээ ашиглан шимтгэлээ төлөх боломжтой болов.*

*Тэтгэвэр тогтоох, олгох үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулж, хяналтыг сайжруулж, үйлчилгээний хугацааг багасгав.*

➤ Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр тогтоох, олгох үйл ажиллагаа, тэтгэврийн байцаагч ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн зохион байгуулснаар үйлчилгээний хугацаа багассан. Мөн тэтгэвэр тогтоолт, олголтод тавих хамтын хяналт сайжирч, ажил үйлчилгээний шат болгонд тухайн ажлыг хариуцах ажилтнуудын ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвар дээшилсэн.

➤ Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор олон улсын чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг амжилттай хэрэгжүүлж байна. 2018 онд Төв, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Төв аймгийн Жаргалант сум ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, батламжаа гардан авлаа.

*Нийгмийн даатгалын байгууллага нь олон улсын ISO 9001:2015 стандартад нийцсэн "Чанарын удирдлагын тогтолцоо"-г амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.*

*"Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил"-ийн хүрээнд салбарын ажилтнууд, иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудын хэрэгцээнд зориулсан дараах програм хангамжуудийг шинээр боловсруулан нэвтрүүллээ.*

➤ Энэ онд шинээр нэвтрүүлсэн програм хангамжууд:

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг шалгах" вэб програм хангамж
- "Төрийн цахим мэдээлэл солилцох ХУР систем"-д холбогдох шинэ сервис
- "Зайн сургалт" вэб програм хангамж
- "Тоон гарын үсгээр баталгаажуулсан тайлан хүлээн авах" вэб програм хангамж
- "Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцыг цахимаар хянах" вэб програм хангамж
- "Дуудлагын төвд ирж буй асуулт, хариултыг бүртгэх" вэб програм хангамж
- "Банкны данс хүлээлгийн горимд шилжүүлэх" вэб програм хангамж
- "Даатгуулагчид туслах" вэб програм хангамж
- "Нийгмийн даатгал" гар утасны аппликейшн болно.

#### 4.4. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлалын чиглэлээр

Улсын хэмжээнд эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоор тогтоогдсон хөдөлмөрийн чадвараа алдсан 111 464 иргэн байгаагаас нийгмийн даатгалын сангаас 69 827 иргэн, нийгмийн халамжийн сангаас 41 637 иргэн тэтгэвэр, тэтгэмж авч байна.

Мөн улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 11 195, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулсан 88 416, цуцлуулсан 9 125, нас барсан 2 728, хөдөлмөрийн нөхцөл сольсон 107, ажлын цаг хорогдуулсан 16 иргэн (даатгуулагч) байна.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанарыг сайжруулах аян"-ыг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 5 сарын хугацаатай зохион байгуулж, нийт 17 462 иргэн (даатгуулагч)-ий тэтгэврийн хувийн хэргийг цахим мэдээллийн сантай тулган шалгаж, 4 206 зөрчлийг

арилгаж, 55 иргэн (даатгуулагч)-ээс ирүүлсэн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэв.

Орхон, Баянхонгор, Булган, Хэнтий, Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст дахин магадлалыг зохион байгуулж, нийт 4 989 даатгуулагч (иргэн)-ийн тахир дутуугийн хувийн хэргийг шалгаж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 51 даатгуулагч (иргэн)-ийг дахин магадлалд хамруулж, 5 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 3 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг Эрүүл мэндийн яамны Мэргэжлийн салбар зөвлөлөөр дүгнэлт гаргуулан шийдвэрлүүлэв.

Мөн бүрдмэл магадлалаар Баян-Өлгий аймагт 1 050, Сэлэнгэ аймагт 838, Говь-Алтай аймагт 945, нийт 2 833 даатгуулагч (иргэн)-ийг хамруулж, 1 219 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр, 204 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 131 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмж, 108 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг бууруулж, 264 иргэний заалтыг өөрчилж, 241 иргэний хугацааг өөрчилж, 242 иргэний оношийг өөрчилж шийдвэрлэв.

#### **4.5. Хяналт шалгалтын үр дүн**

Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь, Ховд, Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд нийгмийн даатгалын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Шалгалтаар нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль зөрчиж илүү, дутуу тооцож олгосон, ажилгүйдлийн тэтгэмжийн даатгалын сангаас давхардуулан олгосон мөн тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг илүү бодож олгосон зэрэг 362.9 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлэн Улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж, 322.2 сая төгрөг буюу 88.8 хувийг барагдуулж ажиллаад байна. Дээрх 6 аймгийн 51 аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, 18 байгууллагын 446 даатгуулагчтай холбоотой 896.0 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 189.8 сая төгрөгийн шимтгэл, 82.2 сая төгрөгийн алданги, нийт 272.0 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, 100 хувь барагдуулав.

Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн байдал

Хүснэгт 8.

№	Аймаг, дүүргийн нэр	Тэтгэврийн даатгалын сан /илүү -дутуу/	Тэтгэмжийн даатгалын сан /илүү -дутуу/	Ажилгүйдлийн даатгалын сан /илүү -дутуу/	Төлбөр, зөрчлийн дүн	Барагдуулалт	Үлдэгдэл	Хувь
1	Баянхонгор	11,9	-	0,3	12,2	12,2	0	100,0
2	Булган	9,8	4,7	5,9	20,5	10,2	10,3	49,6
3	Дундговь	1,1	-	6,1	7,3	6,8	0,4	93,4
4	Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-
5	Ховд	28,1	-	13,5	41,7	16,4	24,2	39,4
6	Сэлэнгэ	3,1	-	5,8	8,9	4,4	4,7	49,5
	<b>Аймгийн дүн</b>	<b>54,1</b>	<b>4,7</b>	<b>1,7</b>	<b>90,6</b>	<b>50,1</b>	<b>40,5</b>	<b>-</b>
1	Аж ахуйн нэгж байгууллага	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос НДШ төлөөгүй зөрчилд			272,3	272,3	-	100
	<b>Нийт төлбөр зөрчлийн дүн</b>				<b>362,9</b>	<b>322,4</b>	<b>40,5</b>	<b>88,8</b>

Мөн дээрхи аймгуудад Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”, ХНХ-ын Сайдын 2018 оны 77 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”, НДЕГ-ын даргын 2018 оны “Заавар батлах тухай” А/09 тоот тушаалын хэрэгжилтийг орон нутагт хангуулах ажлыг газар дээр нь зохион байгуулж ажиллав. Говьсүмбэр, Дундговь аймгийн 13 суманд “Зөвлөл” байгуулах ажлыг удирдан зохион байгуулж, зөвлөлийн 66 гишүүдэд дүрмийн заалт, хурлаас гарах шийдвэр, бүрдүүлэх баримт бичгийн талаар танилцуулж, цаашид анхаарах асуудлаар мэдээлэл зөвлөгөө өгөв.


Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын дүнд Нийгмийн даатгалын тухай хууль зөрчсөн нийт 388 зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийсэн. Үүнээс 4 хэрэгт зөрчлийн хэрэг үүсгэн, 304 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 3 зөрчлийн хэргийг харьяаллын дагуу Сэлэнгэ, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлэн, 77 зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулахаас татгалзсан. Зөрчлийн хэрэг үүсгэсэн 2 аж ахуйн нэгж, байгууллагад “Шийтгэлийн хуудас”-аар 6.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, улсын төсөвт төвлөрүүллээ.

#### 4.6. Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа

2018 оныг “Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил” болгон зарлаж, нийгмийн даатгалын үйл ажиллагааг цахим технологи, арга хэлбэрээр дэмжих, мэдээллийн урсгалын нэгдсэн хяналтын тогтолцоог сайжруулах, үйлчилгээг хөгжүүлэх, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, Иргэн /даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, Ажил олгогчийн


нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт гэсэн 4 төрлийн мэдээллийг Төрийн үйлчилгээний цахим машинаас авдаг болсон.



Иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нэрийн данс, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтын дэлгэрэнгүй мэдээллээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр цахимаар авах, хяналт тавих боломжтой аппликейшн програм хангамжийг шинээр нэвтрүүллээ. “Нийгмийн даатгал” аппликейшнд мөн нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомж, мэдээ мэдээлэл, нийгмийн даатгалын байгууллагуудын хаяг байршил, холбоо барих утасны дугаар зэргийг байршуулсан. Одоогийн байдлаар 36.2 мянган даатгуулагч гар утсандаа суулгаж, 16.8 мянган

даатгуулагч мэдээллээ баталгаажуулан үйлчилгээ авсан байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглагдаж буй нийт 60 гаруй програм хангамжуудад Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, НДҮЗ, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан хууль, тогтоомж, аргачлал, зааварчилгаа болон хэрэглэгчийн хүсэлтийн дагуу нийтдээ 142 удаагийн өөрчлөлт, сайжруулалт, хөгжүүлэлт хийж, төв орон нутгийн байгууллагуудад ашиглах боломжийг бүрдүүллээ.



#### 4.7. Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах

Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах талаар анхаарч ажилласан. Үүнд:

- Салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг 681 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 18 713 байцаагч, ажилтан хамрагдсан.
- Ажил олгогч, даатгуулагчдад зориулсан 3241 удаагийн сургалтад нийт 250803 хүнийг хамруулсан.
- “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлах нээлттэй өдөрлөг”-ийг улсын хэмжээнд 2 удаа зохион 13225 иргэнд, үүнээс: 2217 даатгуулагчдад сайн дурын даатгалын гэрээ байгуулж, шимтгэл төлөх үйлчилгээг, 2613 даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх үйлчилгээг, 5523 даатгуулагчдад нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээ баталгаажуулах үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Мөн нийгмийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах талаар анхаарч ажилласан бөгөөд нийгмийн даатгалын салбарын



хэмжээнд хэвлэл мэдээллийн 83 байгууллагатай хамтран ажиллаж, нийт 676 удаагийн давтамжтайгаар мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтлэлийг тархаасан.

#### 4.8. Түншлэл, хамтын ажиллагаа

Монгол улсаас нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай ОХУ-тай байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх болон Турк, Казахстан, Польш, Чех Улсуудтай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинээр байгуулахаар ажиллаж байна. Эдгээр хэлэлцээрээр даатгуулагчид харилцан төлсөн шимтгэлдээ ногдох тэтгэврийг тэдгээр улсын ижил төрлийн сангаас авах боломж бүрдэх бөгөөд өндөр насны тэтгэврээс гадна ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж авах эрх хоёр талдаа харилцан үүсэх ач холбогдолтой юм.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албатай хоёр орны иргэд тэтгэврийн даатгалд шимтгэл төлөхөөс харилцан чөлөөлөгдөх хугацааг 60 /5 жил/ сар гэж заасан байсныг сунган 108 сар буюу 9 жил болгон тохиролцож, протоколд гарын үсэг зурлаа. Мөн тэтгэврийн даатгалд шимтгэл төлөхөөс чөлөөлөгдөхийг өөрчилж, хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэмж тооцох зэрэг нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үндэсний тэтгэврийн албатай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 65 иргэний 135.9 сая вонн нэхэмжилснээс 62 иргэний 132.7 сая вонны буцаан олголт олгож, 1558 даатгуулагчийн нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулж, 600 даатгуулагч нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авч, 335 даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээжээ.

Хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу 2018 онд давхардсан тоогоор нийт 47 иргэний Монгол Улсад болон Бүгд найрамдах Унгар Улсад ажилласан хугацааны мэдээллийг харилцан солилцож, Монгол Улсын 35 иргэн сард нийт 311230 форинт буюу 2.7 сая, жилд 33.2 сая төгрөгийн тэтгэвэр авч байна

#### 4.9. Лавлах үйлчилгээний талаар

Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний чанар, ажилтнуудын харилцааны талаарх мэдээллийг 7777-1289 утсаар хүлээн авч байгаа бөгөөд 2018 онд нийт 181695 дуудлага ирсэн. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын тухай-14 хувь буюу 25437
- Сайн дурын даатгалын талаар -15 хувь буюу 27254
- Малчны тэтгэврийн талаар-5 хувь буюу 9084
- Тэтгэмжийн даатгалын тухай - 35 хувь буюу
- Ажил олгогчын шимтгэл төлөлт - 15 хувь буюу 27254
- Харьяа дүүргийн байршил, холбоо барих утас, данс - 5 хувь буюу 9084
- Шимтгэлийн хувь хэмжээ - 10 хувь буюу 18169
- Санал гомдол 1 хувь буюу 1816 ирсэн бөгөөд хариуг шуурхай өгч ажиллалаа.

Мөн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх зорилгоор харааны бэрхшээлтэй 2 иргэнийг лавлах үйлчилгээний ажилд авч ажиллуулж байна.

## 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ

- **Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллалаа**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл 2018 онд 9 удаа хуралдаж, нийгмийн даатгалын салбарын өмнө тулгамдсан 31 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 16 тогтоол шийдвэрийг баталж, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад мөрдүүлэн, нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, ажиллалаа.

- **Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийг хэрэгжилтийг хангаж эхэллээ.**

Малчдын өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулсан хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулснаар 6.8 мянган малчинд тэтгэвэр тогтоож, тэтгэвэрт 12.1 тэрбум төгрөг зарцуулав. Түүнчлэн 337 сум, 3 дүүрэгт Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл байгуулагдан ажиллаж, 1693 малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 1442 малчны малчнаар ажилласан хугацааг тодорхойлж, эдгээр малчинд өндөр насны тэтгэвэр тогтоосон.

- **Тэтгэврийн хэмжээ 9 орчим хувиар нэмэгдэж, дундаж тэтгэврийн хэмжээ 342.7 мянган төгрөгт хүрсэн байна.**

2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 393.5 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээ 27.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 280.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 243.0 мянган төгрөг болов.

- **Тэтгэврийн зээлийн хүүг дахин бууруулав.**

Тэтгэвэр олгодог арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 2018 онд 12 сар хүртэлх тэтгэврийн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 3-6 пунктээр бууруулан, сарын 1 хувь, жилийн 12 хувь болгосноор нийт 43290 тэтгэвэр авагч 42.1 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр авч, тэтгэвэр авагчид 1.6 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна.

- **Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 178.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлэв.**

Нийгмийн даатгалын санд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,301.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1,911.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын

төлөвлөгөөг 109.8 хувиар биелүүлсэн. Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн нийт орлого 2017 онд ДНБ-ний 7.8 хувьтай тэнцэж байсан бол 2018 онд ДНБ-ний 4.3 хувьтай тэнцэж байна /Эрүүл мэндийн даатгалын сан хасагдсан/.

- **Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулан, хадгаламжийн хүүгээр сангийн орлогыг өсгөсөн.**

2018 онд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдэлээс 439.3 тэрбум төгрөгийг арилжааны 10 банкинд байршуулж, 56.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь өмнөх оноос хадгаламжийн хэмжээ 155.8 тэрбум, хүүгийн орлого 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

- **Нийгмийн даатгалын байгууллага цайны цагийн завсарлагагүйгээр иргэдэд үйлчилж эхэллээ**

Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд тасралтгүй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үдийн цайны завсарлагагүйгээр үйлчилгээ үзүүлж байна.

- **Төрийн үйлчилгээний цахим машинаас нийгмийн даатгалын тодорхойлолтоо авдаг болов.**

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, Иргэн /даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт гэсэн 4 төрлийн мэдээллийг Төрийн үйлчилгээний цахим машинаас авдаг боллоо.

- **Иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүссэн үедээ авдаг болов.**

“Нийгмийн даатгал” аппликейшн програм хангамжийг шинээр нэвтрүүлсэнээр иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нэрийн данс, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтын дэлгэрэнгүй мэдээллээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр цахимаар авах, хяналт тавих боломжтой боллоо. Энэхүү аппликейшныг одоогийн байдлаар 36.2 мянган даатгуулагч гар утсандаа суулгаж, 16.8 мянган даатгуулагч мэдээллээ баталгаажуулан үйлчилгээ авсан байна.

- **Нийгмийн даатгалын сангийн хуримтлагдсан өр, авлагыг барагдуулж байна.**

Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн 2010 оноос хойш хуримтлагдсан 5.3 тэрбум төгрөгийн өрнөөс 2018 онд 1.2 тэрбум төгрөгийн өр авлагыг барагдуулав.

- **Шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн хуулийн зохицуулалт хэрэгжиж эхэллээ.**

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тус тус 1.0 пунктээр нэмэгдүүлэн 8.0 хувь болгон өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулснаар 2018 оны байдлаар тэтгэврийн даатгалын санд 1,139.2 тэрбум төгрөг хуримтлуулсан бөгөөд энэ нь 2017 онтой харьцуулахад 258.9 тэрбум төгрөгөөр өссөн.

- **Тэтгэврийн параметрийг өөрчилсөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулав.**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэврийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн, 20 жил 3 сараас дээш хугацаанд шимтгэл төлсөн бол 60/55 насандаа тэтгэвэр тогтоолгох зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулав.

## **6. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл 2019 онд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийгмийн даатгалын эрх зүйн тогтолцоог шинэчлэх, сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, захиран зарцуулалт, санхүүгийн менежментийг ил тод болгох, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлж ажиллана.

Энэ хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийн төслийн санал, холбогдох тооцоолол, хийх
- Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах чиглэлээр бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах
- Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Ажил олгогчийн болон даатгуулагчийн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг тус тус 0.5 хувиар нэмэгдүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангуулах
- Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулах хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах
- 2020 оноос хэрэгжүүлэх хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох,

төрүүлж, өсгөсөн хүүхдийн тоогоор эхийн ажилласан хугацааг нэмэгдүүлэн тооцох, 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийн зардлын тооцоо судалгааг хийж, нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөлд тусгуулах

- Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх арга хэмжээний зардлын тооцоо судалгааг хийж, нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөлд тусгуулах
- Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, сангийн хөрөнгийн менежментийг сайжруулах ажлыг оновчтой зохион байгуулах
- Нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, явуулын үйлчилгээ нэвтрүүлэх, цахим үйлчилгээг өргөжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын архивын үйлчилгээг сайжруулах, цахим архивыг бүрдүүлэх
- Нийгмийн даатгалын ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор Сургалтын төв байгуулах, томоохон сургалтууд зохион байгуулах
- Нийгмийн даатгалын цахим үйлчилгээнд хяналт тавьж, техник, технологи, програм хангамжийн найдвартай, шуурхай байдалд ахиц гаргах.

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг шаардлагатай үедээ орон зай, цаг хугацаа үл хамааран хүртэх нөхцөл бүрдэнэ.

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРТ ХОЛБОГДОХ  
ЭРХ ЗҮЙН АКТЫН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

(2018 оны жилийн эцсийн байдлаар)

Шийд- вэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<b>Нэг. Засгийн газрын тогтоол</b>					
<b>№71</b>	/1 дүгээр хавсралт/	<b>Журам батлах тухай 2018.03.14 №71</b>  /1 дүгээр хавсралт/  "Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам"	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д заасны дагуу малчинд тэтгэвэр тогтоолгох насыг 5 жилээр наашлуулах заалт орж, 2018.01.01-ний өдрөөс хэрэгжиж байна. Уг хуулийн заалтаар нийтдээ 20-оос доошгүй, үүнээс 15 жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас, нийтдээ 20-оос доошгүй, үүнээс 12 жил 6 сар малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ.  Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас 2018.03.14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан "Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам", "Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/77 дугаар тушаалаар баталсан "Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"-ийг аймаг,	100% /Бүрэн хэрэгжсэн/	

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

<p><b>№71</b></p>	<p>/2 дугаар хавсралт/</p>	<p><u>Журам батлах тухай 2018.03.14 №71</u>  /2 дугаар хавсралт/  “Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам”</p>	<p>Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дээрх хуулийн заалт хэрэгжиж эхэлснээс хойш 2018 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 337 сум, 3 дүүрэгт зөвлөл байгуулагдан ажиллаж, 1693 малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 1442 малчны малчнаар ажилласан хугацааг тодорхойлж, эдгээр малчинд өндөр насны тэтгэвэр тогтоосон.</p>	<p>Засгийн газрын 2018.03.14-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам”-ыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж байна. Уг журам хэрэгжиж эхэлснээс хойш 2018 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд эрэгтэй 60 нас, 20 жил 3 сар ажилласан нөхцөлөөр 4417, эмэгтэй 55 нас, 20 жил 3 сар ажилласан нөхцөлөөр 5274, эрэгтэй 20 жил 3 сарыг хангаагүй 60 нас 3 сартай нөхцөлөөр 746, эмэгтэй 20 жил 3 сарыг хангаагүй 55 нас 3 сартай нөхцөлөөр 2069 иргэн, олон хүүхдийн нөхцөлөөр 50 настай тэтгэвэр тогтоолгосон 1938, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл буюу газрын дор нөхцөлөөр 12, хортой халуун нөхцөлөөр 214, хүнд нөхцөлөөр 1292 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№30</b></p>	<p>1, 2</p>	<p><u>Журам, жагсаалт батлах тухай 2018.01.31 №30</u>  1. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах журмыг 1 дүгээр хавсралт, Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ</p>	<p>Нийгмийн даатгалын байгууллага нь “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах журам”-ын дагуу уг сүлжээнд холбогдсон. Энэхүү сүлжээгээр Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-д зааснаар төрийн</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>	

		<p>байгуулах, ашиглах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.</p> <p>2. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор баталж, энэхүү сүлжээгээр мэдээлэл солилцож, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.</p>	<p>байгууллагуудтай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>	
<p><b>№16</b></p>	<p>1, 2</p>	<p><b><u>Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2018.01.19 №16</u></b></p> <p>1. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 27000 /хорин долоон мянган/ төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож олгохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.</p> <p>2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280000 /хоёр зуун наян мянган/ төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 243000 /хоёр зуун дөчин гурван мянган/ төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.</p>	<p>Засгийн газрын 2018 оны Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 16 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 27000 төгрөгөөр, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 243.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосныг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг А/07 тушаалаар батлуулав.</p> <p>Дээрх арга хэмжээний үр дүнд 393,5 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээ нэмэгдэж, дундаж тэтгэврийн хэмжээ 342.7 мянган төгрөгт хүрсэн байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>



<p><b>258</b></p>	<p>Бүх заалт</p>	<p><b><u>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22. №258</u></b></p> <p>Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 4, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т заасныг тус тус үндэслэн төрийн бүх шатны байгууллагад сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын бүх гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>1.1. харъяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх</p> <p>1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн</p>	<p>Ийнхүү тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлснээр 1 сард олгох тэтгэврийн хэмжээ 9 орчим хувиар нэмэгдсэн байна.</p> <p>1.1.Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь тус жилийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, салбар нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэн биелэлтийг улирал бүр нэгтгэн авч, дүгнэн ажиллаж байна. 2018 онд үр дүнгийн гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтан, албан хаагч байхгүй байна.</p> <p>1.2.Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д 2018 оны байдлаар нийт 127 санал хүсэлт ирүүлснийг тухай бүр иргэн-даатгуулагчтай утсаар холбогдож хариултыг өгч ажилласан. Хариу өгөөгүй, хүлээгдэж буй санал хүсэлт байхгүй байна.</p> <p>1.3.Засгийн газрын 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтцийг батлах тухай” А/25 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орж, үүний дагуу байгууллагын нэгжүүдийн чиг үүргийг боловсруулах ажлын хэсэгт дэд дарга, газрын дарга, холбогдох ажилтнууд ажиллаж:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын хэрэгжилт, судалгааны газар</li> <li>• Санхүү, бүртгэлийн газар</li> <li>• Хяналт, шалгалтын газар</li> <li>• Дотоод, аудит, мониторингийн газар</li> <li>• Тамгын газар</li> <li>• Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар</li> </ul> <p>НДЭГ-ын дэргэдэх газар:</p>	
-------------------	------------------	---	---	--

<p>байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;</p> <p>1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;</p> <p>1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;</p> <p>1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох;</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс</li> <li>• Мэдээллийн технологийн төв</li> <li>• Бүгд Найрамдах Солонгос Улс дахь нийгмийн даатгалын үйлчилгээний алба</li> </ul> <p>гэсэн 9 нэгжийн чиг үүргийг Газрын даргын 2018 оны А/23 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>1.4. Төрийн жинхэнэ албан тушаалын 23 сул орон тоо гарсны 9 нь тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас, 8 нь холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн мэргэжлийн түвшингээр нь сонгон шалгаруулж томилсон.</p> <p>1.5 НДЕГазар болон харьяа байгууллагуудын хэмжээнд 14 удирдах албан тушаалтны ажлын байрыг нийтэд зарлах, нэр дэвшүүлэхээр Төрийн албаны зөвлөл болон ХНХЯамны төрийн албаны салбар зөвлөлд захиалга, саналыг хүргүүлж, 6 Удирдах албан тушаалд дүгнэлт гаргуулж томилсон. Мөн 4 удирдах албан тушаалтны ажлын байранд Нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулахаар хүргүүлсэн. УИХурлын 2013 оны 13 дугаар тогтоолын дагуу 5 удирдах албан тушаалтны дүгнэлтийг салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөлөөр гаргуулахаар хүсэлт тавьсан.</p> <p>1.6 Хуулийн дагуу түр чөлөөтэй байгаа төрийн албан хаагчийн оронд Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын дагуу томилоог хийж, сул ажлын байранд гэрээгээр томилогдон ажиллаж байгаа 6 төрийн албан хаагчийг нээлттэй сонгон шалгаруулалтад оруулснаас 3 төрийн албан хаагчид дүгнэлт гаргуулахаар Төрийн албаны зөвлөлд нэр дэвшүүлэн хүргүүлсэн байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
--	--	-------------------------------

	<p>1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;</p> <p>1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч, дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;</p> <p>1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах</p> <p>1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;</p>	<p>1.9 Ажилтан албан хаагчдын цагийн бүртгэлийг хурууны хээ уншигч төхөөрөмжийн тусламжтайгаар бүртгэлжүүлж, Агле програмын цагийн бүртгэл цэсээр дамжуулан хяналт тавин ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод журмыг шинэчлэн боловсруулж, цагийн бүртгэлд тавих хяналт, хариуцлагын асуудлыг нарийвчлан зохицуулж өгсөн. Одоогийн байдлаар ажлын цаг ашиглалт хангалтгүй гэсэн шалтгааны улмаас сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна. Мөн тус газар нь хяналтын камерыг тусгал бүхий тодорхой цэгүүдэд суулган хяналт тавин ажиллаж байна.</p>	
--	---	---	--

		<p>1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, зэрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;</p>		
<p><b>264</b></p>	<p>1</p>	<p><u>Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай 2018.08.22 №264</u></p> <p>1. ... төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод жишгийг 6 дугаар хавсралт, ...Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 9 дүгээр хавсралт ... ёсоор тус тус шинэчлэн баталж, 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.</p>	<p>Уг тогтоолын дагуу Төрийн захиргааны 64 төрийн албан хаагч, төрийн үйлчилгээний 21 төрийн албан хаагчийн цалинг НДЕГазрын даргын 2018 оны А/169, А/170 дугаар тушаалаар шинэчлэн тогтоож, 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоод байна. НДЕГазрын хэмжээнд төрийн албан хаагчдын сарын цалин 5097379 төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.</p> <p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>	
<p><b>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн дундаж 100 хувь</b></p>				
<p><b>Хоёр. Засгийн газрын албан даалгавар</b></p>				
<p><b>№01</b></p>	<p>2.2.</p>	<p><u>Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 2018.07.09 №01</u></p> <p><b>2.2. Төрийн байгууллагуудад:</b></p> <p>2.2.1. Төрийн байгууллагуудад хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн зэрэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, сонсголыг тогтмол</p>	<p>Газрын даргын 2018 оны А/215 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй "Эцэг эхийн зөвлөл" байгуулагдан, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2018 онд Хүүхдийн хөгжлийн онцлог, Гэр бүлийн харилцаа сэдвээр мэдээллийн цагаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан.</p> <p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>	

		Засгийн газрын албан даалгаарын хэрэгжилтийн дундаж 100 хувь	
		Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	
	зохион байгуулах, бүх байгууллагуудад “Эцэг эхийн зөвлөл” байгуулж, Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллуулах		
<b>№17</b>	<p><b>Төсвийн ерөнхийлөн захирагч нарт</b> <b>2018.04.18 №17</b></p> <p>1. Яамд хариуцан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, мөн аймаг, нийслэлд шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, эрчимжүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгав.</p>	<p>Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр НДЕГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр А/34 дугаар тушаалаар төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар төслийн менежерүүдийг томилсон. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засварын ажлын сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, холбогдох баримтыг 2018 оны 05 дугаар сард багтаан ирүүлэхийг үүрэг болгож тухай бүрд нь заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Их засвар төсөл арга хэмжээний хүрээнд 13 төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмж төсөл арга хэмжээний хүрээнд 2 төсөл арга хэмжээ, нийт 15 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn цахим системээр амжилттай зохион байгуулж ажиллалаа.</p>	100% /Бүрэн хэрэгжсэн/
<b>№16</b>	<p><b>Засгийн газрын агентлагийн дарга нарт</b> <b>2018.04.04 №16</b></p> <p>1. Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернэтийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа компьютерийг олон</p>	<p>1. НДЕГ-ын ажилтнууд болон аймаг, нийслэл, дүүргийн НДХ-ийн албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж байгаа компьютерээс олон нийтийн сүлжээ /FB, twitter/-нд нэвтрэх эрхийг хаасан.</p> <p>2. Засгийн газрын “Сахилга хармуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж хэрэгжүүлэн</p>	

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>нийтийн сүлжээнээс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд интернэтийг зөвхөн албан ажлынхаа хүрээнд ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулан ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт даалгав.</p> <p>2. Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.</p>	<p>ажиллаж байна. 5 дэд бүлэг, 30 заалт бүхий уг төлөвлөгөөнд албан хаагчдын сахилга хариуцлага, цаг ашиглалтын талаар тодорхой заалтууд тусгасан бөгөөд аймаг, дүүргийн НДХ-үүдэд хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№16</b></p>	<p>1, 1.2, 1.3, 1.4</p>	<p><b><u>Төсвийн ерөнхийлөн захирагч нар</u></b> <b><u>2018.04.04 №16</u></b></p> <p>1. 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар "хангалтгүй" буюу 27.7 хувьтай байх тул</p>	<p>Нийгмийн даатгалын байгууллагуудын 2018 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон shilendans.mn сайтад байршуулсан.</p> <p>Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар төсөл арга хэмжээ, тоног</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>

		<p>тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах; 1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж, нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах;</p> <p>1.2. өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх;</p> <p>1.3. худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах;</p> <p>1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10<sup>1</sup>-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>төхөөрөмж төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулж, ажилласан.</p> <p>Худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn сайтаар дамжуулан ил тод нээлттэй зохион байгуулсан бөгөөд урилга үр дүнг тухай бүр нийтэлсэн.</p> <p>2018 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих төв орон нутгийн 15 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны улирал болон хагас жилийн тайланг тухайн бүрд нь нэгтгэн гаргаж Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны харьяа нэгжид болон Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Мөн худалдан авах ажиллагааны явцын мэдээг 14 хоног тутамд гаргаж Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны худалдан авах ажиллагааны мэргэжилтэнд хүргүүлэн ажиллалаа.</p>	
<p><b>№10</b></p>	<p>IX.3.</p>	<p><b><u>Засгийн газрын агентлагийн дарга нар</u></b> <b><u>2018.02.22 №10</u></b></p> <p>IX.3. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны албан тушаалтанд хандаж иргэдээс 2017 онд "Иргэд, олон нийттэй</p>	<p>Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төв"-д 2018 оны байдлаар нийт 127 санал хүсэлт ирүүлснийг тухайн бүр иргэн-даатгуулагчид хариултыг утсаар мэдэгдэж ажилласан. Хариу өгөөгүй, хүлээгдэж буй санал хүсэлт байхгүй байна. Ирсэн асуудлуудыг ангилбал:</p> <p>Тэтгэвэртэй холбоотой 61 буюу 48%,</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн</p>

		<p>харилцах төв"-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов" гэжээ.</p>	<p>Тэтгэмжтэй холбоотой 17 буюу 13%, НДШ-тэй холбоотой 8 буюу 7%, Хөнгөлөлттэй эмийн тухай 9 буюу 7%, ЭМДШ-тэй холбоотой 5 буюу 3,9%, НД-ын хууль, эрх зүйтэй холбоотой 13 буюу 10,2%, Тэтгэврийн зээлийн хүү буурсантай холбоотой 9 буюу 7%,</p> <p>Үйлчилгээтэй холбоотой санал, гомдол 5 буюу 3,9% -ийг эзэлж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д ирсэн өргөдөл гомдлыг тухай бүр хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, харьяалах дээд байгууллага Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд улирал бүр Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хүргүүлэн ажиллаж байна.</p>	
<p><b>№32</b></p>	<p>2.3</p>	<p><b><u>2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлах тухай 2018.01.31 №32</u></b></p> <p>2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх;</p>	<p>Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газар нь тус жилийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, салбар нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэн биелэлтийг улирал бүр нэгтгэн авч, дүгнэн ажиллаж байна. 2018 онд үр дүнгийн гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтан, албан хаагч байхгүй байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн</p>
<p><b>№26</b></p>	<p>XIX.3.1.</p>	<p><b><u>Агентлагийн дарга нарт 2018.06.13 №26</u></b></p> <p>1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох</p>	<p>Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллаж байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн</p>



<p><b>№28</b></p>	<p>28.VIII</p>	<p>хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов.</p> <p><b><u>Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай</u></b> <b><u>2018.06.27 №28.VIII</u></b></p> <p>1. Захиргааны байгууллагуудын хүнд суртлыг багасгах, тэдгээрийн шийдвэр гаргах чадавхийг бэхжүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгаж, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв:</p> <p>1.1. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг</p>	<p>Дээрх тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичиг, ... тайлагнах хугацаа”-нд заасны дагуу 02 дугаар сарын 1-ний өдрийн дотор тайлагнаж ХНХЯ-ны холбогдох газарт хүргүүлнэ.</p>	
			<p>Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>Үүнд:</p> <p>-Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байгаа хууль тогтоомжийн судалгааг гарган жагсаалтыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>-Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас гаруулан авч холбогдох судалгааг хийж, дагаж мөрдөх шаардлагагүй болсон, хууль тогтоомжтой давхардсан тушаалыг хүчингүй болгож Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажилласан байна.</p> <p>Үүнд:</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/212 дугаартай тушаалаар НДЕГ-ын даргын 1999 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 84 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход баримтлах итгэлцүүрийг хэрэглэх журам”-ыг,</p> <p>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дугаартай тушаалаар НДЕГ-ын даргын 2002 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгаас нийслэл болон</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн</p>

		<p>эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ дагуу хянан үзэж, цэгцлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;</p> <p>1.2. Ач холбогдлоо алдаж дагаж мөрдөх шаардлагагүй болсон хууль, тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгож, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч 2018 оны IV улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;</p> <p>1.3. Өөрийн салбарт дагаж мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гарган, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, шаардлагатай бол тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2018 онд багтаан хэрэгжүүлэх;</p>	<p>төв суурин газар түр оршин суугч иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах журам"-ыг тус тус хүчингүй болгосон байна.</p>	
<p><b>№31</b></p>	<p>1-5</p>	<p><b><u>Засгийн газрын агентлагийн дарга нар</u></b>  <b><u>2018.08.01. 31 дүгээр тэмдэглэл</u></b></p> <p>1. УИХ болон Байнгын хорооны тогтоол, МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар,</p>	<p>2018 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын нийт 16 шийдвэрийн 49 заалт байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт заалтын 26</p>	

	<p>сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;</p> <p>2. Үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" /www.ipeelge.gov.mn/-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр эрх бүхий байгууллагад тайлагнах;</p> <p>3. 2018 оны эхний хагас жилийн байдлаар хангалтгүй үнэлэгдсэн, тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;</p> <p>4. Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тогтмол гардаг шийдвэр, заалтыг тухай бүр нь хяналтаас хасуулж хэвших;</p> <p>5. Хууль тогтоомжид заасан эрх зүйн акт /дүрэм, журам, заавар, бусад/-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>/53.1%/ нь бүрэн биелэгдсэн, 20 /40.8%/ нь хэрэгжилтийн шатанд, 3 /6.1%/ нь хэрэгжих боломжгүй байгаа бөгөөд биелэлтийн дүн дунджаар 85.95 хувьтай, "Сайн" гэж үнэлэгдлээ. Хяналтад байгаа нийт 16 шийдвэрийн 14 буюу 87.5 хувь нь 2018 он гарснаас хойш, 11 шийдвэр буюу 68.8 хувь нь 2018 оны 03 дугаар сараас хойш хяналтад авсан заалтууд байна. Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/1150 тоот албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн/</p> <p>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын нийт 27 шийдвэрийн 81 заалт байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт заалтын 71 /87.7%/ нь бүрэн биелэгдсэн, 7 /8.6%/ нь 90-ээс дээш хувийн хэрэгжилттэй, 3 /3.7%/ нь хэрэгжих боломжгүй байгаа бөгөөд биелэлтийн дүн дунджаар 97.65 хувьтай, "Маш сайн" гэж үнэлэгдлээ. Хяналтад байгаа нийт 27 шийдвэрийн 25 буюу 92.6 хувь нь 2018 он гарснаас хойш, 2 шийдвэр буюу 7.4 хувь нь 2017 оны 10, 12 дугаар сард хяналтад авсан заалтууд байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн</p>
--	--	--	----------------------------------

<b>№36</b>	1	<p><b><u>Засгийн газрын агентлагийн дарга нарт 2018.08.29. №36</u></b></p> <p>...иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов” гэжээ.</p>	<p>Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д 2018 оны байдлаар нийт 127 санал хүсэлт ирүүлснийг тухай бүр шийдвэрлэсэн.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д ирсэн өргөдөл гомдлыг тухай бүр хугацаанд нь шуурхай шийдвэрлэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд улирал бүр Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хүргүүлэн ажиллаж байна.</p>	100% /Бүрэн хэрэгжсэн
<b>Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн дундаж 100 хувь</b>				
<b>Дөрөв. УИХ-ын Байнгын хорооны хурлын тэмдэглэл</b>				
<b>№01</b>	1-3	<p><b><u>1995 оноос өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээ бага, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн олгуулах зэрэг асуудлаар 600 гаруй иргэдээс ирүүлсэн өргөдлийн тухай 2018.06.12 Дугаар 01</u></b></p> <p>1. 1997 оноос өмнө хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг тусгайлан нэмэгдүүлэх талаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд холбогдох зохицуулалт байхгүй тул Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1997 оноос өмнө хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр</p>	<p>1. Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.</p> <p>Эдгээр хуулиудын төсөлд Нийгмийн даатгалын ерөнхий газраас доорх саналуудыг оруулж, хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Ахмад настан төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай, амьжиргаанд хүрэлцэхүйц тэтгэвэр авах олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдүүлэх;</li> <li>✓ Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгох;</li> <li>✓ Тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийг, технологийг, технологийг, технологийг,</li> </ul>	100% /Бүрэн хэрэгжсэн

		<p>тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг тусгах,</p> <p>2. 1991-1997 оны хооронд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдээс одоо амьд сэрүүн байгаа 21,3 мянган иргэн /олон хүүхэд төрүүлж өсгөсөн 15,4 мянган эхчүүд, нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон 4,0 мянган эмэгтэйчүүд, 1,8 мянган эрэгтэйчүүд/-ний авч байгаа тэтгэврийн талаарх тооцоо, судалгаан дээр үндэслэн тэтгэврийн зөрүүг багасгах арга хэмжээ авах санал боловсруулан тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцлийг шинэчлэн батлуулах,</p> <p>3. 1991-1997 оны хооронд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд, нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг 2019 оны улсын төсөвт оруулж батлуулах нь зүйтэй байна гэсэн саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд /С.Чинзориг/-д хүргүүлэх нь зүйтэй гэж тогтов.</p>	<p>удирдлага, байгууллагын бүтэц, чадавх бий болгох зорилтуудыг дэвшүүлэх зэрэг болно.</p> <p>2. 1995 оноос өмнө тогтоолгосон тэтгэврийн хэмжээ бага, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн олгуулах зэрэг асуудлаар Нийгмийн даатгалын багц хууль, төрөөс тэтгэврийн даатгалын талаар баримтлаж ирсэн бодлого, тэтгэврийн даатгалын эрх зүйн орчин, 1995 оноос өмнөх болон хойшхи тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, судалгааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/1168 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн Ц.Гарамжавт хүргүүлсэн болно.</p> <p>3. 1991-1997 оны хооронд хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд, нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг 3 хувилбараар тооцон, нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсөв, төсөөлөлд тусган Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн болно.</p>	
<b>УИХ-ын Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн дундаж 100 хувь</b>				
<b>Тав. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол</b>				
<b>№05</b>	1, 2, 3, 4, 5, 6	<p><b>Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай 2018.04.17 №05</b></p> <p>1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд /тэтгэврийн даатгал/ албан</p>	<p>НДҮЗ-ийн "Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай" 2018 оны 05 дугаар тогтоолыг хүлээн авч, БНСУ дахь Нийгмийн даатгалын тасарт цахим шуудангаар илгээж, биелэлтийн тайланг гаргаж 2018.12.10-нд холбогдох газарт хүргүүлж ажилласан.</p>	

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>журмаар даатлуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 40000 /дөчин мянган/ вонноос багагүй байхаар тогтоосугай.</p> <p>2. Энэ тогтоолын 1-д зааснаас бусад нөхцлөөр БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд /тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал/ сайн дураар даатлуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 40000 /дөчин мянга/ вонноос багагүй байхаар тогтоосугай.</p> <p>3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.</p> <p>4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай” 19, 20 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p> <p>5. Энэ тогтоолыг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.</p> <p>6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.</p>	<p>БНСУ дахь Нийгмийн даатгалын тасаг нь 2018 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 13971 сая вонн буюу 3148.1 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлжээ.</p> <p>Тайлант хугацаанд шимтгэлийн орлогын 2383.5 сая төгрөг /1057.6 сая вонн/ буюу 75.7 хувийг 2652 албан журмын даатлуулагч, 764.6 сая төгрөг /339.5 сая вонн/ буюу 24.3 хувийг 764 сайн дурын даатлуулагчийн төлсөн шимтгэл эзэлж байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№04</b></p>	<p>1, 2, 3</p>	<p><b>Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай</b> <b>2018.04.17 №04</b></p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/22 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог шинэчлэн 6 газар, дэргэдэх 3 алба, 82 үндсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.</p>	<p>100%</p>

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагын орон тоог Дарга-1, Дэд дарга-2 байхаар тогтоосугай.</p> <p>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай. Үүнд:</p> <p>2.1. Дотоод аудит, мониторингийн газар</p> <p>2.2. Тамгын газар</p> <p>2.2.1. Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс</p> <p>2.2.2. Хуулийн хэлтэс</p> <p>2.2.3. Аж ахуйн алба</p> <p>2.3. Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар</p> <p>2.3.1. Олон нийттэй харилцах хэлтэс</p> <p>2.4. Бодлогын хэрэгжилт, судалгааны газар</p> <p>2.4.1. Судалгааны хэлтэс</p> <p>2.5. Санхүү, бүртгэлийн газар</p> <p>2.5.1. Хуримтлалын сан, ерийн удирдлагын хэлтэс</p> <p>2.6. Хяналт, шалгалтын газар</p> <p>3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд Мэдээллийн технологийн төв, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Бүгд Найрамдах Солонгос Улс дахь нийгмийн хамгааллын төвийн Нийгмийн даатгалын албыг ажиллуулсугай.</p>	/Бүрэн хэрэгжсэн/
№03	1, 2, 3	<p><u>Нэрийн дансны 2017 оны орлогод тооцох хуугийн хэмжээг тогтоох тухай 2018.04.17 №03</u></p>	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу даатгуулагчдын нэрийн дансны 2017 оны орлогод тооцох хуугийн хэмжээг тооцож, Үндэсний статистикийн хорооноос санал авч Нийгмийн

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>1. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2017 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 6.7 хувиар баталсугай.</p> <p>2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод хүү тооцох, нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад хүргүүлэх ажлыг 2018 оны 02 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.</p>	<p>даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Нэрийн дансны 2017 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 03 дугаар тогтоолоор жилийн 6,7 хувиар батлуулж ажилласан.</p> <p>Нэрийн данс нээлгэсэн 1,43 сая даатгуулагчийн нэрийн дансанд хүү тооцсоноор 2017 оны жилийн эцэст нэрийн дансанд 15,4 их наяд төгрөгийг хийсвэрээр бүртгэж, мэдээлэх хуудас хэвлэх бэлтгэл ажлыг хангав.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№01</b></p>	<p>1, 2, 3.</p>	<p><b>Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай</b> <b>2018.01.22 №01</b></p> <p>1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт чиг үүрэг нь шилжиж байгаа албан хаагчдыг шилжүүлэх, мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын балансад бүртгэлтэй хавсралтанд дурдсан 1.950.000.000 /нэг тэрбум есөн зуун тавин сая/ төгрөгийн өртөгтэй конторын барилга, 650.729.006 /зургаан зуун тавин сая долоон зуун хорин есөн мянга зургаа/ төгрөгийн өртөг бүхий 965 ширхэг үндсэн хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэхийг</p>	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн “Үндсэн хөрөнгө шилжүүлэх” тухай 01 тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулан Нийгмийн даатгалын ерөнхий газар түүний харьяа газар хэлтсүүдэд данснаас хасалт хийн шилжүүлж, Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгахыг албан тоотоор хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх” тухай 46 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын балансад бүртгэлтэй 1.950.000.000 /нэг тэрбум есөн зуун тавин сая/ төгрөгийн өртөгтэй конторын</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т зөвшөөрсүгэй.</p> <p>2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн, холбогдох шийдвэрийг гаргуулан. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.</p> <p>3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд үүрэг болгосугай.</p>	<p>барилга, 650.729.006 /зургаан зуун тавин сая долоон зуун хорин есөн мянга зургаа/ төгрөгийн өртөг бүхий 965 ширхэг үндсэн хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэв.</p>	
<p><b>№02</b></p>	<p>1</p>	<p><b>Тогтоол хүчингүй болгох тухай</b> <b>2018.02.05 №02</b></p> <p>1. "Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p>Тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан аймаг, дүүргийн НДХ-үүдэд чиглэл хүргүүлэн ажиллав.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№24</b></p>	<p>1, 2, 3, 4</p>	<p><b>Журам батлах тухай</b> <b>2017.12.19 №24</b></p> <p>1."Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад ажиллуулах нийгмийн даатгалын төлөөлөгчийн тоог баталж, тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ажлын хөлс олгож ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн</p>	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам"-аар ажил олгогч, даатгуулагч, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар судалгаа, үнэлгээ хийх зорилгоор орон тооны бус төлөөлөгч ажиллуулахаар зохицуулсан.</p>	

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

		<p>даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.</p> <p>3. Нийгмийн даатгалын төлөөлөгчтэй байгуулах хөлсөөр ажиллах гэрээний жишиг загварыг баталж, мөрдөн ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Журам батлах тухай" 09 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.</p>	<p>Энэ журмын хүрээнд нийгмийн даатгалын төлөөлөгчтэй байгуулах "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний үлгэрчилсэн загварыг гарган Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлж, орон тооны бус төлөөлөгчийг батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд энэ оны 6 дугаар сараас эхлэн ажиллуулав.</p> <p>2018 онд 62 хүнийг нийгмийн даатгалын орон тооны бус төлөөлөгчөөр ажиллуулж, тэдгээрийн ажлын хөлсөнд 217.7 сая төгрөг олгохоор төсөв батлагдсан бөгөөд 59 иргэнтэй "Хөлсөөр ажиллах гэрээ" байгуулан ажиллуулсаны дүнд 198 ажил олгогч, 5477 иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилан, нийгмийн даатгалд шинээр 35 ажил олгогч, 186 албан журмын даатгуулагч, 542 сайн дурын даатгуулагчийг хамруулан, 114.4 сая төгрөгийн шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэв. Мөн орон тооны бус төлөөлөгчид нийгмийн даатгалын байгууллагын архивын баримт бичгийг цэгцлэх, цахим хэлбэрт шилжүүлэх ажилд оролцсоноор 6,8 мянган ажил олгогчийн 747 архивын нэгжийг мэдээллийн санд оруулсан болно.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>
<p><b>№08</b></p>	<p>1-3</p>	<p><b>Журам, гэрээний загвар шинэчлэн батлах тухай</b>  <b>2018.08.17. №08</b></p> <p>1. "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам"-ыг нэгдүгээр хавсралт, "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.</p>	<p>НДҮЗ-ийн 2018.08.17-ны №08 тоот тогтоол гарч мөнгөн хадгаламжийн шинэ журам хэрэгжиж эхэлснээс хойш 7 банкны 346.4 тэрбум төгрөгийн хадгаламжийг 13,00-13,88 хувийн хүүтэйгээр гэрээг сунгах болон шинээр сангийн чөлөөт үлдэгдлийг хадгаламж хэлбэрээр байршуулаад байна. Өмнө нь арилжааны банкуудтай байгуулсан "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-г гэрээнд заасан хугацаа дуусах хүртэл хүүгийн хэмжээг хэвээр мөрдөн ажиллаж байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>

		<p>2. Энэ тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”, “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-г арилжааны банкуудтай шинээр гэрээ байгуулахад мөрдсүгэй.</p> <p>3. Энэ тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө арилжааны банкуудтай байгуулсан “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-г гэрээ заасан хугацаа дуусах хүртэл хэвээр мөрдсүгэй.</p>			
<p><b>№09</b></p>	<p>1-5</p>	<p><b>Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай</b> <b>2018.08.17. №09</b></p> <p>1. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн 1 жил /365 хоног/-ийн хүүгийн хэмжээг 13.0 хувиас багагүй байхаар тогтоон, шинээр мөнгөн хадгаламж байршуулахад мөрдсүгэй.</p> <p>2. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор эх үүсвэр болгон байршуулж буй мөнгөн хадгаламжийн хэмжээг нийт хадгаламжийн 30 хувиас хэтрүүлэхгүй байх, нэг жил /365 хоног/-ийн хүүгийн хэмжээг тэтгэврийн зээлийн хүү болон тухайн банкны маржины зөрүүгээр тогтсугай.</p> <p>3. Энэ тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл арилжааны банкуудтай байгуулсан “Мөнгөн</p>	<p>Энэ тогтоол гарснаас хойш нийт 7 банкны 14 хадгаламжийн гэрээг сунгах болон шинээр байгуулсан бөгөөд хүүг 13.00-13,88 хувиар тогтоон мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулаад байна.</p> <p>Арилжааны банкуудаас сар болгон санхүүгийн аудитлагдаагүй тайлан, Монгол банкны шалгуур үзүүлэлтийн тайланг холбогдох мэдээний хамт гаргуулан авч шалгуур хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.</p>	<p>100% /Бүрэн хэрэгжсэн/</p>	

		<p>хадгаламжийн гэрээ"-д заасан хүүгийн хэмжээг уг гэрээнд заасан хугацаа дуусах хүртэл хэвээр мөрдсүгэй.</p> <p>4. "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам"-д заасны дагуу банкууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.</p> <p>5. Энэ тогтоолыг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.</p>			
<p><b>№13</b></p>	<p>1-4</p>	<p><b>Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай</b> <b>2018.12.24. №13</b></p> <p>1. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкуудад байршуулах мөнгөн хадгаламжийн 1 жил /365 хоног/-ийн хүүгийн хэмжээг 14.0 хувиас багагүй байхаар тогтоон, шинээр мөнгөн хадгаламж байршуулахад мөрдсүгэй.</p> <p>2. Энэ тогтоолыг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдөхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-д үүрэг болгосугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн</p>	<p>Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг арилжааны банкуудад мэдээлэн мөнгөн хадгаламж байршуулах бэлтгэл ажлыг хийлээ.</p>	<p>/2019 онд хэрэгжинэ/</p>	

		<p>2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн "Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг батлах тухай" 09 дүгээр тогтоолын 1, 5 дах заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p> <p>4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.</p>		
<p><b>НДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилтийн дундаж 88.9 хувь</b></p>				
<p><b>Зургаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал</b></p>				
<p><b>№А/77</b></p>	<p>1, 2, 3</p>	<p><b>Дүрэм батлах тухай</b> <b>2018.03.27 №А/77</b></p> <p>1. "Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Зөвлөлийн тогтоол"-ын заварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p> <p>2. Энэхүү тушаалаар батлагдсан дүрмийг баримтлан даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох ажлыг шуурхай зохион байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/, аймаг, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д заасан малчны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулж, эрэгтэй малчин 55, эмэгтэй малчин 50 настай өндөр насны тэтгэвэр тогтоолгох зохицуулалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Энэ хуулийн дагуу тэтгэвэр тогтоох зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/02, А/09 дүгээр тушаалаар "Малчин-даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар"-ыг боловсруулан аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэн, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.</p> <p>Уг арга хэмжээний хүрээнд 2018 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар нийт 15 мянга гаруй малчин-даатгуулагчид зөвлөгөө өгч, 6384 малчинд өндөр насны тэтгэвэр тогтоож, тэтгэвэрт 10308,9 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын 2018.03.14-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан "Малчинд тэтгэвэр</p>	<p>100% /Хэрэгжих шатанд/</p>

			<p>тогтоход баримтлах журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А77 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”-ийг аймаг, дүүргийн НДХ-үүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2018 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр 337 сум, 3 дүүрэгт зөвлөл байгуулагдан ажиллаж, 1693 малчин жил тодорхойлуулах хүсэлт гаргаснаас 1442 малчны малчнаар ажилласан хугацааг тодорхойлж, эдгээр малчинд өндөр насны тэтгэвэр тогтоосон.</p>	
<p><b>№79</b></p>	<p>2, 2.1, 2.2, 2.3, 2.4</p>	<p><b>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай</b> <b>2018.03.27 №79</b></p> <p>2. Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т дараах арга хэмжээ авч, үр дүнг тогтмол тайлагнаж ажиллахыг үүрэг болгосугай.</p> <p>2.1. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар хоёрдугаар хавсралтад нэр заагдсан аж ахуйн нэгж байгууллагуудад тавьсан нийгмийн даатгалын шимтгэлийн өр, алданги тооцсон төлбөрийг 2018 оны 2 дугаар улиралд барагдуулж дуусгах;</p> <p>2.2. Аж ахуйн нэгж байгууллагуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тухай бүрд нь НД-7, НД-8 маягаар харах</p>	<p>Мэдээллийн технологийн төвийн болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын холбогдох ажилтнууд уулзалт зохион байгуулж Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 159 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын дагуу НДЕГ, ХХҮЕГ-тай байгуулсан мэдээлэл солилцох гэрээний хавсралтад өөрчлөлт оруулан сервис програмаар мэдээлэл солилцохоор болсон.</p> <p>НДЕГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн удирдамжийн дагуу Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр шалгалт зохион байгуулав.</p> <p>Шалгалтад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2016, 2017, 2018 оны 4 дүгээр сарыг дуусталх хугацаанд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн оруулж ирсэн 1828 аж ахуйн нэгж</p>	<p>97.7%</p>

	<p>эрхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хэлтсийн эрх бүхий мэргэжилтнүүдэд нээж өгөх;</p> <p>2.3. Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгал төлөгчдийн тоог хуурамчаар нэмэгдүүлж нийгмийн даатгалын сангийн мэдээллийг өөрчилсөн ажилтан, албан тушаалтанд хариуцлага тооцож, үр дүнг илтгэх;</p> <p>2.4. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан нийт аж ахуйн нэгж байгууллагуудын 2016-2018 оны гадаадын ажиллах хүчний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд хяналт, шалгалт хийж үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах;</p>	<p>байгууллагын мэдээллийг жагсаалтаар авч харьяа аймаг, дүүрэг, нийслэлээр хуваарилан шалгалтыг аж ахуйн нэгж, байгууллагын ажил хариуцсан ажилтан бүртэй ярилцаж, тодруулга авах, зөвлөмж өгөх зэргээр баримтын шалгалт, ярилцлагын болон шинжилгээний аргуудыг голчлон баримталсан ба шаардлагатай тохиолдолд хяналтын бусад аргуудыг ашиглаж ажиллалаа. Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудыг нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас шүүлт хийн шимтгэл төлсөн эсэхийг тодруулан эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагыг ялган авч 50 хүртэлх хувийг шалгахаар зорилт тавин ажиллаж 709 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж гүйцэтгэв. Эдгээр нь Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас авсан 1828 ААНБ-ын 38,7 хувь, нийт хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан 41912 ажиллах хүч, мэргэжилтний 65,9 хувийг тус тус эзэлж байна.</p> <p>Шалгалтад хамрагдсан 709 аж ахуйн нэгж байгууллагын 515 аж ахуйн нэгж байгууллага зөрчилгүй дүгнэгдэж, 194 аж ахуйн нэгж байгууллага буюу 27,3 хувь нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4,15,16,17 дугаар зүйлийг тус тус зөрчиж нийт 16120 даатгуулагчид олгосон 5,7 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос шимтгэл тооцож төлөөгүй байна. Дээрх зөрчилд 976,3 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн ногдуулж түүнд 477,7 сая төгрөгийн алданги ногдуулан нийт 1,4 тэрбум төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоон 2018 оны 12-р сарын 15-ны байдлаар 97,7 хувийг барагдуулан ажиллалаа. Улсын байцаагчийн актыг хугацаандаа</p>
--	---	--

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 1

			<p>барагдуулаагүй учир барагдуулалтын хувиар үнэлгээг өгөв/</p>	
<p><b>№78</b></p>	<p>1, 2</p>	<p><b><u>Эрх шилжүүлэх тухай 2018.03.27 №78</u></b></p> <p>1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжих “Х.5.2.1 Нийгмийн даатгалын байгууллагуудын барилгын их засвар /улсын хэмжээнд/ 1,000.0 сая.төг” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т шилжүүлсүгэй.</p> <p>2. Их засварын төсөл, арга хэмжээг холбогдох хуулийн дагуу шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд нь ирүүлж байхыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.</p>	<p>Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр А/34 дугаар тушаалаар төсвийн нарийвчилсан хуваарь, мөн 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар төслийн менежерүүдийг томилсон.</p> <p>Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засварын ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, зөвлөмж холбогдох баримтыг 2018 оны 05 дугаар сард багтаан ирүүлэхийг үүрэг болгож тухай бүрд нь заавар зөвлөмж өгч ажилласан. Их засвар төсөл арга хэмжээний хүрээнд аймаг дүүргийн нийт 14 их засварын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу амжилттай зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Нийгмийн даатгалын байгууллагуудын барилгын их засвар төсөл арга хэмжээний хүрээнд 14 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны улирал болон хагас жилийн тайланг тухайн бүрд нь гаргаж Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны харьяа нэгжид болон Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>/1 төсөл, арга хэмжээнд хуулийн дагуу 2 удаагийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч шаардлага хангаагүй тул татгалзсан/</p>	<p>93.3%</p>
<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын хэрэгжилтийн дундаж 97.0 хувь</p>			<p><b>НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ 97.65 ХУВЬ</b></p>	



# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 2

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд заалт тус бүрээр нь төлөвлөгөө гарган, дараах ажлуудыг гүйцэтгэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

№	Өгөгдсөн чиглэл	Хэрэгжилт /2018.12.31-ний байдлаар/
1	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм, журмыг гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэж, холбогдох хуулиудад нийцүүлэн өөрчлөлт оруулж батлах.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмэнд холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулан 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар нийт гишүүдийг оролцуулан хэлэлцүүлж, төслийг 2018 оны 06 сарын 14-ний өдрийн 101 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд батлуулахаар хүргүүлсэн. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг баталсан.
2	Нийгмийн даатгалын сан тус бүрийн сарын зарлагыг нарийвчлан тооцох, арилжааны банкинд байршуулахдаа харилцах, хадгаламжийн зохистой харьцааг хангах, банкуудын хадгаламжийн дундаж хүүг баримтлан нэн даруй байршуулах, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрт шилжүүлэх.	Нийгмийн даатгалын сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарь, 2018 оны сар бүрийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зэрэг үзүүлэлтүүдийн үр дүнд үндэслэн арилжааны банкуудад хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийг тооцоолон, харилцах дансанд байсан мөнгөн хөрөнгийг хугацаатай хадгаламжид шилжүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээ 300.0 тэрбум төгрөгөөр батлагдсан боловч Сангийн яам бонд гаргах нь тодорхойгүй байснаас шалтгаалан хадгаламж байршуулах ажлууд эхний улиралд хойшлогдсон байсан.

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 2

<p>Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-т “Хуримтлалын сангаас арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно” гэж заасны дагуу 2018 онд арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 600.0 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоож баримтлан ажилласан.</p> <p>Дээрх мөнгөн хөрөнгийн хэмжээг ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн хувьд тооцоолж, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны харилцах дансны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан орлого, зарлага, холбогдох судалгааг үндэслэн гаргасан болно.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 тоот тогтоолоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”, “Мөнгөн хадгаламжийн гэрээ”-ний загварыг шинэчлэн батлуулан мөрдөж байна.</p> <p>Түүнчлэн тус өдрийн 09 тоот тогтоолоор мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг 13.0 хувиас багагүй байхаар тогтоон хэрэгжүүлээ. Энэхүү журам, хүүгийн хэмжээг Монголбанк, Сангийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас саналуудыг авч тусган, хүүгийн хэмжээг тогтоохдоо Монголбанкны бодлогын хүү, арилжааны банк хоорондын захын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ болон Монголбанкнаас ирүүлсэн “хугацаатай хадгаламжийн хүүг Монголбанкнаас тогтоосон бодлогын хүүн дээр гурван пунктээр нэмж тогтоох” саналыг тус тус үндэслэсэн болно.</p> <p>Монголбанкны бодлогын хүү 11.0 хувь болж өөрчлөгдсөн тул Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 13 тоот тогтоолоор мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг 14.0 хувиас багагүй байхаар тогтоолоо.</p>	
---	--

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

### Хавсралт 2

Тухайн жилд “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-д заасан шаардлага хангаж буй банкуудтай 20 мөнгөн хадгаламжийн гэрээг шинээр байгуулж, 376.8 тэрбум төгрөгийн хадгаламжийг байршуулсан байна.

Мөн 141.5 тэрбум төгрөг байршиж буй 11 мөнгөн хадгаламжийн гэрээг сунгаж, 221.0 тэрбум төгрөг байршиж буй 14 гэрээг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй, тайлан мэдээг ирүүлээгүй, тогтоосон хүүгийн хэмжээнээс доош хүүг санал болгосон, тэтгэврийн хөнгөлөлттэй зээлийн хэмжээ буурсан шалтгаануудаар тус тус цуцалсан болно.

Капитал болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкаас бусад банкууд Монголбанкнаас тавигддаг банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллаж байна.

Үндэсний хөрөнгө оруулалтын банк нь 2018 оны 10 дугаар сараас эхлэн 5 шалгуур үзүүлэлтийг хангаагүй байсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Капитал банктai 2007 онд “Хамтран ажиллах гэрээ” байгуулан харилцах болон хадгаламж хэлбэрээр мөнгөн хөрөнгө байршуулж эхэлсэн бөгөөд Нийгмийн даатгалын сангийн 2016 оны санхүүгийн тайланд тусгагдсанаар 180.0 тэрбум төгрөгийн хадгаламж, 44.1 тэрбум төгрөгийн харилцах, нийт 224.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршиж байсан болно. Энэхүү мөнгөн хөрөнгөөс 2019 оны эхэнд эрүүл мэндийн даатгалын сангийн 132.5 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлсэн. Капитал банк нь харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийхгүй, тайлан мэдээг ирүүлэхгүй байгаа учир Нийгмийн даатгалын ерөнхий газраас Банкны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан бичиг удаа дараалан хүргүүлэн, удирдлагын уулзалтыг зохион байгуулж байсан боловч үр дүнд хүрэлгүй өнөөдрийг хүрээд байна. Сүүлийн жилүүдэд Капитал банкинд хадгаламж нэмж байршуулаагүй боловч мөнгөн хөрөнгө нь харилцах болон хадгаламжийн хүүгийн орлогоор нэмэгдэн өнөөдрийн байдлаар Нийгмийн

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 2

		<p>даатгалын ерөнхий газрын харилцах дансуудад мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс нийт 101.6 тэрбум төгрөг харилцах дансанд байршиж байна.</p> <p>Капитал банкаас хадгаламж байршуулах хүсэлтийг удаа дараа ирүүлж байсан ч Монголбанкаас тогтоосон "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ын дагуу шалгуур зарим үзүүлэлтийг хангаагүй, гэрээнд заасан тайлан мэдээг ирүүлээгүй тул хугацаа дууссан хадгаламжийн хугацааг сунгаагүй ба харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгийг хадгаламжид шилжүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байна.</p> <p>Иймд эдгээр 2 банктai хугацаа дууссан хадгаламжийг үргэлжлүүлэн сунгаагүй болно.</p>
<p>3</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдах, хүүгийн орлогыг нэмэгдүүлэх, хадгаламжид байршуулалгүй харилцахад байршуулж байгаагаас учирсан хохирлыг шийдвэрлэх арга хэмжээ авах.</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газар нь нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдах, хүүгийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд мөнгөн хадгаламж байршиж буй банкуудын санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, Монголбанкаар хянагдсан банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг сар бүр хүлээн авч, нягтлан, шалгуурыг хангаж буй эсэхэд судалгаа, шинжилгээ хийж холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг зөв зохистой удирдах, хүүгийн орлогыг нэмэгдүүлэх, хадгаламжид байршуулалгүй харилцахад байршуулж байгаагаас учирсан хохирлыг шийдвэрлэх зорилгоор Банкны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар Монгол банкнд хандан албан бичиг удаа дараалан хүргүүлэн, удирдлагын уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Энэ зорилгоор Капитал банкнд шинээр байршуулсан 79.0 тэрбум төгрөгийн "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-г 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн байгуулсан бөгөөд холбогдох тооцооллыг хийж, энэ хугацааны хүүгийн орлого болох 2.46 тэрбум төгрөгөөр нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нэмэгдэх боломж бүрдлээ. 2018 оны жилийн эцсийн байдлаар арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого болох 56.6 тэрбум төгрөг</p>

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 2

		<p>нийгмийн даатгалын санд төвлөрсөн нь өмнөх оноос 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.</p>
<p>4</p>	<p>Чөлөөт мөнгөн үлдэгдлийн арилжааны банкинд байршуулах дээд хязгаарыг тогтоож, банкны өөрийн хөрөнгө болон эрсдэл даах, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай нь уялдуулан байршуулах, олон нийтийн хяналт болон хариуцлагын тогтолцоог тодорхойлох зэргээр чөлөөт мөнгөн хөрөнгийн удирдлагыг журмаар зохицуулах бус хуульд нарийвчлан тусгасан хуулийн төслийг намрын чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>Монгол Улсын тогтвортой байдлын үзэл баримтлал, тэтгэврийн шинэчлэл, малчдын талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны АГЗ дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Малчдын тэтгэврийн даатгалын тухай, Ажилгүйдлийн болон тэтгэмжийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиудын төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулан УИХ-ын 2019 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газарт Нийгмийн даатгалын багц хууль болон хуулийн үзэл баримтлалын төсөл, танилцуулга боловсруулах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажлын хэсгийг мэдээллээр хангаж, дэмжиж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой судалгаа, тооцоолол хийж цаг тухайд нь шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлалын төсөлд нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн арга хэрэгсэлд оруулах, хяналт болон хариуцлагын тогтолцоог зохицуулах заалтуудыг оруулсан болно.</p> <p>Дээрх хуулиудын үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн ямаар батлууллаа.</p>
<p>5</p>	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн нийгмийн даатгалын сангийн</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулахдаа чөлөөт өрсөлдөөний зарчмыг ханган банкуудад</p>

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хавсралт 2

	<p>чөлөөт мөнгөн хөрөнгийг байршуулахдаа арилжааны банкуудын чөлөөт өрсөлдөөний зарчмыг хангаж ажиллах, холбогдох гэрээг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан улирал тутамд шинэчилж байх.</p>	<p>мэдээллийг тэгш хүргэн хадгалах мөнгөн дүн, хүүгийн хэмжээний саналуудыг авч байна.</p> <p>“Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-д заасны дагуу хадгаламж байршиж буй банкуудаас сар бүр санхүүгийн болон Монголбанкны санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буй тайланг хүлээн авч, шалган, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Монголбанкны мөнгөний бодлогын хүү, банкуудын нийтэд зарласан нэг жилийн хугацаатай байгууллагын хадгаламжийн хүүг сар бүр авч, судалгаа хийн ажиллаж байна.</p> <p>Монголбанкны бодлогын хүү өөрчлөгдсөн үед буюу 2018 оны 08, 12 дугаар саруудад мөнгөн хадгаламжийн нэг жилийн хүүгийн хэмжээг шинэчлэн тогтоож, мөрдөн ажиллаж байна.</p>
6	<p>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн мэдээллийг улирал бүр Байнгын хороонд ирүүлж байх.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн мэдээлэл, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг улирал бүр гаргуулан Байнгын хороонд хүргүүлэн ажиллаж байна.</p>
7	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жилийн ажлынхаа тайланг Монгол Улсын Их чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.8-д заасан хугацаанд нь ирүүлж, цаашид хуулийн хугацаа хэтрүүлэхгүй байх.</p>	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны жилийн үйл ажиллагааны тайланг 03 дугаар сарын 28-ны өдрийн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулж, 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдөр Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд хүргүүлсэн.</p>

-----000-----